



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ”
ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ Ц.МИНЖИНХҮҮ
ТАНАА

2018.03.15 № 06/713
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2018\0315SAG45.Docx

071008

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

“Налайхын дулааны станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0315SAG40.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



Аудитын код: САГ-2018/60/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663, Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууня
Утас: 261885, Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитор: Н.Нямдаваа
Утас: 260512, Цахим хаяг: nyamdavaan@audit.gov.mn

“Лидер экаунт аудит” ХХК-ийн захирал, Аудитор П.Шаравхорол
Утас: 7011-4519, Цахим хаяг: sharav_8054@yahoo.com

Ахлах аудитор Д.Лхамсүрэн
“Лидер экаунт аудит” ХХК
Утас: 7011-4519, Цахим хаяг: lhama_0324@yahoo.com

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	1
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Авлагын талаар	4
2.9.2	Анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар.....	4
2.9.3	Тооллого тооцооны талаар.....	4
2.9.4	Бусад асуудлын талаар.....	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	6
3	Менежментийн захидал	7
3.1	Авлагын талаар	7
3.2	Анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар	7
3.3	Тооллого тооцооны талаар.....	7
3.4	Бусад асуудлын талаар.....	7
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, тодруулга	8
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	10
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	11
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.5	Аудит хийгдсэн тодруулгын тайлан	13



Аудитын тайлан

2.1 Оршил

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн аудитын тайланг тус сургуулийн захирал Ц.Минжинхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд бараа материалын тооллогын тооцоог нэгтгэж баримтжуулах, он дамжсан авлагыг барагдуулах, анхан шатны баримтыг бүрдүүлэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд “Лидер экаунт аудит” ХХК гурван талт гэрээний үндсэн дээр аудит хийв. /САГ-2018/60/СТА-ТӨҮГ/

Аудитыг Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тус байгууллага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг



алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 1-нээс 2018 оны 3 дугаар сарын 9-ний хооронд хийхээр төлөвлөн “Лидер экаунт аудит” ХХК-ийн аудитын багийн гишүүн аудитор П.Шаравхорол, аудиторын туслах Ш.Уянга нар гүйцэтгэв.

Тус байгууллага нь 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 74 тоот албан бичгээр “Лидер экаунт аудит” ХХК-д ирүүлсэн.

Аудитын тайлан, гэрчилгээг 2018 оны 3 дугаар сарын 15-нд “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн удирдлагад хүргүүлнэ.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Налайхын дулааны станц” ТӨХК нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын ерөнхий хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй байна.

“Налайхын дулааны станц” ТӨХК нь дулааны эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн тусгай зөвшөөрөл эзэмшин борлуулалт хийж, тоноглолын засвар үйлчилгээгээ хариуцан Налайх дүүргийн төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг дулааны эрчим хүчээр хангахын зэрэгцээ үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах, эдийн засаг санхүүгийн чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Энэ байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд /ТАБ-СТА-А-1/ маягтад тодорхой тусгасан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нэрийг үйлсэн горим, сорил 12-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Unicus” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлд зааснаар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоод хяналтын ажлыг байгууллагын хуулийн ажилтан зохион байгуулан ажиллаж, хөрөнгө мөнгөний зарцуулалт, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийсэн нүүрсний гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийж ажилласан байна.

2.6 Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Тус компани нь 2017 онд 128.0 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн түгээхээр төлөвлөж, 123.1 мян.Гкал дулаан үйлдвэрлэж, төлөвлөгөөг 96.2 хувиар биелүүлжээ. Төлөвлөгөөгөөр борлуулалтын орлогоор 2,754.2 сая төгрөг олохоос 2,907.3 сая төгрөгийн орлого олж, борлуулалтын орлогын төлөвлөгөөг 105.6 хувиар биелүүлсэн байна. Нийт 5,186.8 сая төгрөгийн зардал гаргахаас 4,254.3 сая төгрөгийн зардал гаргаж, зардлыг 932.5 сая төгрөгөөр хэмнэж, үйл ажиллагааны бус орлогоор 64.2 сая төгрөгийг олж, улсын төсвөөс алдагдлын татаас 1,272.7 сая төгрөг авч, нийт дүнгээр 1,109.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаас 10.1 сая төгрөгийн алдагдалтай буюу төлөвлөгөөт алдагдлыг 99.1 хувиар бууруулж ажиллажээ.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны зорилтот түвшний төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, 2018 оны зорилтот түвшний төлөвлөгөө, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 12 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 1.0 сая төгрөгөөс дээш 3,992.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл зэрэг дансуудын ажилгүйгээ, **01** **ДӨРЖИЛГҮЙ** **САНАЛ ДҮГНЭЛТ**

үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт мөнгөн хөрөнгийн 60.0 хувийг, нийт зардлын 60.0 хувийг, нийт хөрөнгийн 65.0 хувийг тус тус эзэлж байна.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад авлага, өглөгтэй холбоотой материаллаг бус алдаа илэрсэн. Үүнд:

2.9.1 Авлагын талаар

14 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй холбоотой үүссэн 19.1 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогч тодорхойгүй, нас барсан, холбогдох баримтгүй он дамжсан авлага байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, найдваргүй болсон авлагыг тогтоон хуулийн дагуу холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөх.

2.9.2 Анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар

Тус байгууллага 2017 онд “Нуган трейд” ХХК-д 3.0 сая төгрөг, “СИАЛ” ХХК-д 4.1 сая төгрөгийн нүүрсний үнийг, “Бодончийн Билэг” ХХК-д 5.0 сая төгрөгийн барааны үнийг тус тус шилжүүлэхдээ үндсэн баримтгүй шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах заалтыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2.9.3 Тооллого тооцооны талаар

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого тооцоог нэгтгэж баримтжуулаагүй, тайлан, илтгэх хуудас байхгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг хийж, баталгаажуулна” гэснийг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтыг мөрдөх, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг чанартай гүйцэтгэж, тооцоог нэгтгэн дүгнэж тайлагнаж байх.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.9.4 Бусад асуудлын талаар

Тус байгууллага 2004 оны 12 дугаар сарын 1-нд Эрчим хүчний судалгаа хөгжлийн төвд чингэлэгийн үнэнд 850.0 мянган төгрөгийг шилжүүлэн, чингэлэгийг хүлээн аваагүй байхад өглөгийн дансаар дамжуулан үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв чингэлэгийг нийлүүлэхээ больж, 2006 оны 6 дугаар сарын 8-нд чингэлэгийн үнэ 850.0 мянган төгрөгийг буцаан авсан байна. Үндсэн хөрөнгөд хий бүртгэсэн чингэлэгийг одоо хүртэл үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасаагүй төдийгүй 2009 онд явагдсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр 1,385.5 мянган төгрөгийн үнэтэй болсон байна.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгөнд хий бүртгэсэн 1,385.5 мянган төгрөгийн асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэхээр зөвлөмж өгөх.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 07 дугаар сарын 03-ны 194 дүгээр тогтоолоор Нийслэлийн Налайх дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг баталж, батлагдсан тарифыг 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахаар шийдвэрлэсэн ч төсвийн байгууллагуудын халаалтын зардлын нэмэлт санхүүжилт нь 2017 оны төсөвт суугдаагүй тул 2018 оноос эхлэн шинэ тарифаар тооцож эхэлсэн байна.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад дараагийн аудитаар авч үзэх материаллаг асуудал гараагүй.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

14 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй холбоотой үүссэн 19.1 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогч тодорхойгүй, нас барсан, холбогдох баримтгүй он дамжсан авлага байна.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 6 зөвлөмж өгсөний 5 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Харин шинээр нүүрсний зарцуулалтын хэмжүүр худалдан авах асуудал 2017 оны төсөвт суугдаагүй учраас 2018 оны төсөвт суулгаж хэрэгжүүлэхээр хариу ирүүлсэн байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов. Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зарлагын 4,254.3 сая төгрөгнөөс 1.0 хувиар тооцож, 42.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 12 хуудас, хавсралтууд 28 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

Хоёр дахь шатанд хянасан: “Лидер экаунт аудит” ХХК-ийн захирал	/П.Шаравхорол/
Анхан шатанд хянасан: Чанарын хяналтын менежер	/И.Юмчиндулам/
Бэлтгэсэн: Ахлах аудитор	/Д.Лхамсүрэн/

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 1: Авлагын талаар

Тэргүүлэх ач олбогдол №1

Ажиглалт :

Авлага үүсээд 3-7.5 жил болсон одоогоор эзэн холбогдогч нь тодорхойгүй, нас барсан, авлагыг шүүхээр шийдвэрлүүлэх гэхээр холбогдох баримт материалгүй 14 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй холбоотой 19,150.3 мянган төгрөгийн авлага байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Авлагыг барагдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, найдваргүй болсон авлагыг тогтоон хуулийн дагуу холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд:

- Найдваргүй авлага нэмэгдэж хөрөнгө зүй бусаар зарцуулагдах
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх

Үйлчлүүлэгчийн хариу

Өгсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**Асуудал 2: Анхан шатны баримт
бүрдүүлэлтийн талаар**

Ажиглалт :

Тус байгууллага 2017 онд “Нуган трейд” ХХК-д 3,000.0 мянган төгрөг, “СИАЛ” ХХК-д 4,063.5 мянган төгрөгийн нүүрсний үнийг, “Бодончийн Билэг” ХХК-д 5,000.0 мянган төгрөгийн барааны үнийг тус тус шилжүүлэхдээ үндсэн баримтгүй шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

- Хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

Тэргүүлэх ач олбогдол №1

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Өгсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 3: Тооллогын талаар

Ажиглалт :

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого тооцоог нэгтгэж баримтжуулаагүй, тайлан илтгэх хуудас байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг хийж, баталгаажуулна” гэснийг мөрдөөгүй байна.

Эрсдэлүүд:

Өмч хөрөнгө дутагдах, шамшигдах эрсдэлтэй

Тэргүүлэх ач олбогдол №1

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтыг мөрдөх, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг чанартай гүйцэтгэж, тооцоог нэгтгэн дүгнэж тайлагнаж байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Өгсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 4: Бусад асуудлын талаар

Тэргүүлэх ач олбогдол №1

Ажиглалт :

Тус байгууллага 2004 оны 12 дугаар сарын 1-нд Эрчим хүчний судалгаа хөгжлийн төвд чингэлэгийн үнэнд 850.0 мянган төгрөгийг шилжүүлэн, чингэлэгийг хүлээн аваагүй байхад өглөгийн дансаар дамжуулан үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв чингэлэгийг нийлүүлэхээ больж, 2006 оны 6 дугаар сарын 8-нд чингэлэгийн үнэ 850.0 мянган төгрөгийг буцаан авсан байна. Үндсэн хөрөнгөд хий бүртгэсэн чингэлэгийг одоо хүртэл үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасаагүй төдийгүй 2009 онд явагдсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр 1,385.5 мянган төгрөгийн үнэтэй болсон байна.

Зөвлөмж

Үндсэн хөрөнгөнд хий бүртгэсэн 1,385.5 мянган төгрөгийн асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэхээр зөвлөмж өгөв.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд:

- Толилуулга ба илчлэл тодруулга, Үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх,
- СТОУС, бусад хууль журам зөрчигдөх, Санхүүгийн тайлангийн мэдээлэл алдаатай, буруу илрхийлэгдэх эрсдэлтэй

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ:

Хоёр дахь шатанд хянасан: “Лидер экаунт аудит” ХХК-ийн захирал	/П.Шаравхорол/
Анхан шатанд хянасан: Чанарын хяналтын менежер	/И.Юмчиндулам/
Бэлтгэсэн: Аудитор	/Э.Учралзаяа/

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2017 оны 1 сарын 1	2017 оны 12 сарын 31
	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	70,659,909.88	80,881,732.63
1.1.02	Дансны авлага	323,788,586.57	406,560,961.20
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.04	Бусад авлага	-	-
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.06	Бараа материал	180,916,709.61	250,749,668.98
1.1.07	Урьдчилж төлсөн зардал / тооцоо	16,973,060.00	883,560.00
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг-н бус хөрөнгө	-	-
1.1.10	Бусад	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	592,338,266.06	739,075,922.81
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	2,516,844,616.80	5,360,858,458.86
1.2.02	Биет бус хөрөнгө	66,711,250.00	42,711,250.00
1.2.03	Биологийн хөрөнгө	-	-
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.07	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.09	Дуусаагүй барилга	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,583,555,866.80	5,403,569,708.86
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,175,894,132.86	6,142,645,631.67
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	1,716,949,904.30	1,756,900,880.80
2.1.1.02	Цалингийн өглөг	-	-
2.1.1.03	Татварын өр	202,858,527.29	156,396,898.35
2.1.1.04	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.05	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.06	Хүүний өглөг	-	-
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12	Бусад	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,921,375,104.83	1,917,237,899.24
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,921,375,104.83	1,917,237,899.24
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	3,392,872,148.47	3,392,872,148.47
2.3.02	- хувийн	-	-
2.3.03	- хувьцаат	-	-
2.3.04	Халаасны хувьцаа	-	-
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	531,843,250.00	531,843,250.00
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	-	2,980,994,308.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(2,670,196,370.44)	(2,680,301,974.04)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(10,105,603.60)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(2,670,196,370.44)	(2,670,196,370.44)
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,254,519,028.03	4,225,407,732.43
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,175,894,132.86	6,142,645,631.67

Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого /цэвэр/	2,773,962,840.22	2,907,309,605.08
2	Борлуулалтын өртөг	4,043,378,820.85	4,116,971,592.74
3	Нийт ашиг (алдагдал)	(1,269,415,980.63)	(1,209,661,987.66)
4	Түрээсийн орлого	0.00	2,696,045.46
5	Хүүний орлого	2,113,088.66	6,553,016.12
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	59,799,221.45	54,940,282.28
8.1	Орлогын дүн	61,912,310.11	64,189,343.86
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	122,917,651.82	137,360,232.54
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
12.1	Зардлын дүн	172,441,465.67	137,360,232.54
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	1,272,727,272.73	1,272,727,272.74
17.1	Олз гарзын дүн	1,272,727,272.73	1,272,727,272.74
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(107,217,863.46)	(10,105,603.60)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(107,217,863.46)	(10,105,603.60)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(107,217,863.46)	(10,105,603.60)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	0.00	0.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,440,061,343.25	4,394,828,264.37
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,957,702,039.25	2,938,821,493.37
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	11,143,304.00	17,915,671.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		14,000,000.00
1.1.5	Татаас, санхүүжилтын орлого	1,400,000,000.00	1,400,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	71,216,000.00	24,091,100.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,378,732,617.03	4,381,377,295.46
1.2.1	Ажиллагсадд төлсөн	981,794,363.00	1,153,590,343.16
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	279,463,603.40	332,193,395.09
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	154,940,558.00	159,232,298.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	880,454,503.00	522,979,870.11
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,682,285,269.28	1,491,165,720.04
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	7,947,267.34	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	174,428,597.44	465,458,173.97
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		1,463,320.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	217,418,455.57	255,294,175.09
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	61,328,726.22	13,450,968.91
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,360,610.16	6,960,853.84
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,247,521.50	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,113,088.66	6,960,853.84
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8	Бусад	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,290,000.00	10,190,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	6,290,000.00	10,190,000.00
2.2.6	Бусад	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНЛ ДҮНДЭЛТ
(2,929,389.84) (3,229,146.16)

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	109,400,000.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	109,400,000.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Бусад	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	110,000,000.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	110,000,000.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Бусад	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(600,000.00)	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	57,799,336.38	10,221,822.75
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,860,573.50	70,659,909.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	70,659,909.88	80,881,732.63

Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	3,392,872,148.47	0.00	0.00	531,843,250.00	0.00	0.00	(2,562,978,506.98)	1,361,736,891.49
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	3,392,872,148.47	0.00	0.00	531,843,250.00	0.00	0.00	(2,562,978,506.98)	1,361,736,891.49
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	107,217,863.46	(107,217,863.46)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2016 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	3,392,872,148.47	0.00	0.00	531,843,250.00	0.00	0.00	(2,670,196,370.44)	1,254,519,028.03
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	3,392,872,148.47	0.00	0.00	531,843,250.00	0.00	0.00	(2,670,196,370.44)	1,254,519,028.03
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(10,105,603.60)	(10,105,603.60)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	2,980,994,308.00	0.00	2,980,994,308.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**


“НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2017 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	3,392,872,148.47	0.00	0.00	531,843,250.00	0.00	2,980,994,308.00	(2,680,301,974.04)	4,225,407,732.43

Аудит хийгдсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Үйл ажиллагааны чиглэл: Дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 оны гүйцэтгэл	2017		Зөрүү
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт					
а/ Гол нэрээр					
Дулаан үйлдвэрлэлт	Биет	120.90	128.00	123.10	(4.90)
б/ Үнийн дүнгээр	мян. төг	-			-
Нийт орлого	мян. төг	2,835,875.00	2,804,212.20	2,971,499.00	167,286.80
Үүнээс: Цэвэр борлуулалт	мян. төг	2,773,962.80	2,754,212.20	2,907,309.70	153,097.50
Хүүний орлого	мян. төг	2,113.10	2,000.00	6,553.00	4,553.00
Бусад орлого/Маягт, тендер техникийн нөхцөл, үнсний, алданги торгуулийн, угаалгын, засвар үйлчилгээний орлогууд/		57,799.10	48,000.00	57,636.30	9,636.30
Нийт зардал	мян. төг	4,215,820.20	5,186,786.80	4,254,331.40	(932,455.40)
Үүнээс: удирдлагын зардал	мян. төг	108,311.80	108,291.00	100,633.00	(7,658.00)
Татварын өмнөх ашиг/алдагдал/	мян. төг	(1,379,945.20)	(2,382,574.60)	(1,282,832.40)	1,099,742.20
Улсын төсвийн татаас	мян. төг	1,272,727.30	1,272,727.30	1,272,727.30	-
Цэвэр ашиг, алдагдал	мян. төг	(107,217.90)	(1,109,847.30)	(10,105.10)	1,099,742.20
Төсвийн төлбөрт нийт дүн	мян. төг	-	-	-	-
а/ Орлогын татварт	мян. төг	-	-	-	-
б/ НӨАТ	мян. төг	254,062.50	254,062.50	450,744.30	196,681.80
в/ НДШ	мян. төг	279,463.60	178,718.30	403,125.40	224,407.10



“НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

г/ ХХОАТ	мян. төг	112,390.40	112,390.40	141,350.60	28,960.20
д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян. төг	5,826.30	8,102.80	5,828.10	(2,274.70)
е/ Тээврийн хэрэгслийн татвар	мян. төг	419.40	847.60	311.50	(536.10)
ж/ Бусад татвар /Газрын төлбөрт/ Төрийн өмчийн ногдол ашигт	мян. төг	1,268.20	1,268.20	1,266.10	(2.10)
Нийт ажиллагсдын тоо	мян. төг	114.00	114.00	114.00	-
Нийт цалингийн сан	мян. төг	1,206,093.30	1,462,231.50	1,435,876.70	(26,354.80)
Нэг ажиллагчийн дундаж цалин	мян. төг	881.60	1,068.90	1,049.60	(19.30)
Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	мян. төг	34,870.30	40,521.80	35,026.50	(5,495.30)
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян. төг	1.50	1.90	1.50	(0.40)
Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян. төг	57,798.90	213,920.00	43,159.40	(170,760.60)
Нийт авлага	мян. төг	323,788.60	380,000.00	406,594.00	26,594.00
Үүнээс: Найдваргүй	мян. төг	-	-	-	-
Нийт өглөг	мян. төг	1,921,375.10	1,900,000.00	1,917,240.90	17,240.90
Үүнээс: Богино хугацаат	мян. төг	1,921,375.10	1,900,000.00	1,917,240.90	17,240.90
Урт хугацаат	мян. төг	-	-	-	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**